


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 1 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар буюу 2-р долоо хоногт нийт Нийслэлийн 7 дүүрэг, 2 аймагт **151** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 151 тохиолдлын 90% /136/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 10% /15/ нь орон нутагт (Баян-Өлгий /4/, Төв /5/, Өвөрхангай /3/, Говь-Алтай /3/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **38** тохиолдол Чингэлтэй дүүрэгт бүртгэгдсэн байна.

2 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.01.04 – 2026.01.10)

2026 оны эхний долоо хоногт 75 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдөөгүй бол 5 жилийн дунджаас 17.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **2-р долоо хоногт** нийт **58** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **эхний долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **26** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 36.8 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 136.4 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (2-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	4	7
2	Эмийн хордлого	10	9	19
Нийт		13	13	26

Нийт 26 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 19 (73%) нь эмийн хордлого, 7 (27%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 13 (50%) тохиолдол, санаатай хордлого 13 (50%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.